



МОНГОЛ УЛС
СҮХБААТАР АЙМГИЙН ЗАСАГ
ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 30 өдөр

Дугаар А/663

Баруун-Урт сум

Орон нутгийн өмчийн газрын бүтэц, зохион
байгуулалтыг шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21, 66 дугаар зүйлийн 66.1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.5, 14.2.12, Засгийн газрын 2021 оны “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тооны хязгаарыг тогтоох тухай” 377 дугаар тогтоол, Засгийн газрын Хэрэг Эрхлэх газрын 2023 оны 10 дугаар сарын 10-ны өдрийн ХЭГ/2198 албан бичгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын дэргэдэх хэрэгжүүлэгч агентлаг Орон нутгийн өмчийн газрын бүтэц, зохион байгуулалтаас Худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулагдаж байгаа тул Орон нутгийн өмчийн газрын дүрмийг нэгдүгээр, бүтэц зохион байгуулалт орон тоог хоёрдугаар хавсралтаар тус тус шинэчлэн баталж, тус захирамжийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

2. Худалдан авах ажиллагааны газар шинээр байгуулагдаж байгаатай холбогдуулан Орон нутгийн өмчийн газраас шилжин томилогдох албан хаагч, эд хөрөнгийн хамт шилжүүлэх арга хэмжээ авахыг Орон нутгийн өмчийн газар (Ө.Тайвансанаа)-т даалгасугай.

3. Батлагдсан газрын бүтэц, орон тоо, дүрмийг чанд мөрдөж ажиллахыг Орон нутгийн өмчийн газар (Ө.Тайвансанаа)-т үүрэг болгосугай.


4. Орон нутгийн өмчийн газрын орон тооны бүтэцтэй уялдуулан үйл ажиллагааны чиг үүргийг хэрэгжүүлэхэд шаардлагатай байр, албан тасалгаагаар хангах, зохион байгуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

5. Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагаанд шаардагдах төсвийг 2024 оны орон нутгийн төсөвт тусгаж шийдвэрлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Ариунжаргал)-т зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Мөнхзаяа)-д даалгасугай.


7. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2023 оны 02 дугаар сарын 06-ны өдрийн “Орон нутгийн өмчийн газрын бүтэц, зохион байгуулалтыг өөрчлөн батлах тухай” А/55 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцугай.

ЗАСАГ ДАРГА



М.ИДЭРБАТ

2023 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн
А/553 дугаар захирамжийн нэгдүгээр хавсралт



“ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗАР” ТБАГ-ЫН ДҮРЭМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү дүрэм нь аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар, ТБАГ (цаашид “газар” гэх)-ын үйл ажиллагааны зарчим, чиг үүрэг, бүтэц, ажлын зохион байгуулалт, төрийн болон орон нутгийн өмчийн харилцааг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн зохицуулахад оршино.

1.2. Газар нь үйл ажиллагаандаа Төрийн албаны тухай хууль, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Иргэний хууль, Компанийн тухай хууль, Төрийн хяналт, шалгалтын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль болон тэдгээртэй нийцүүлэн гаргасан бусад хууль эрх зүйн актууд болон Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төв байгууллага, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал, аймгийн Засаг даргын гаргасан шийдвэрүүд болон холбогдох хууль эрх зүйн актуудыг мөрдлөг болгоно.

1.3. Орон нутгийн хэмжээнд төрийн болон орон нутгийн өмчийн талаарх бодлогыг аймаг, сумын хэмжээнд хэрэгжүүлэх, хяналт тавих, зөвлөгөө өгөх ажлыг эрхлэх чиг үүрэг бүхий Засаг даргын дэргэдэх агентлаг мөн.

1.4. Орон нутгийн өмчийн газрын үйл ажиллагааны зардлын төсвийг аймгийн Засаг даргын өргөн барьснаар аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал баталж, орон нутгийн төсвөөс санхүүжүүлнэ.

1.5. Газар нь үйл ажиллагааны чиглэлийн дагуу төрийн санд харилцах данстай, нягтлан бодох бүртгэлийн тайлан тэнцэл гаргаж, жил бүр аймгийн Засаг дарга, Төрийн аудитын газарт тайлагнана.

Хоёр. Газрын бүтэц, удирдлага, зохион байгуулалт

2.1. Орон нутгийн өмчийн газар нь Засгийн газрын 2021 оны 12 дугаар сарын 14-ний өдрийн “Аймгийн Засаг даргын Тамгын газрын бүтэц, орон тоо, хязгаарыг тогтоох тухай 377 дугаар тогтоолыг үндэслэн тус газрын дүрэм, бүтэц, орон тоог аймгийн Засаг дарга батална.

2.2. Газрын дарга бүрэн эрхийн хүрээнд тушаал гаргана.

2.3. Газрын мэргэжилтэн, ажилтнуудыг газрын дарга томилж, чөлөөлнө.

2.4. Газар нь ажлаа аймгийн Засаг даргын өмнө бүрэн хариуцна.

2.5. Өөрийн чиг үүрэг, зорилтыг хэрэгжүүлэхэд шаардлагатай эд хөрөнгийн жагсаалт, зардлын тооцоог санхүүгийн жил эхлэхээс өмнө гаргаж, дараа жилийн орон нутгийн төсөвт тусгуулан шийдвэрлүүлнэ.

2.6. Албан хаагчдын ажлын байр, тоног төхөөрөмж, албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах асуудлыг Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль холбогдох дүрэм, журамд нийцүүлэн шийдвэрлэнэ.

2.7. Газар нь хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгүүлж, улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээ авах ба хэвлэмэл хуудас, тэмдэг хэрэглэнэ.

2.8. Газар нь Хөдөлмөрийн тухай хууль тогтоомжид нийцүүлэн байгууллагын хөдөлмөрийн дотоод журмыг батлан мөрдүүлнэ.

2.9. Газар нь орон нутгийн өмчит хуулийн этгээдийн үйл ажиллагааны төлөвлөгөө, төлөвлөлт, зорилтот түвшинг тодорхойлсон барим бичгүүд боловсруулахад оролцох ба удирдлага, мэргэжил арга зүйгээр ханган, үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллана.

2.10. Газрын дарга байгууллагын гүйцэтгэлийн байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг байгуулж, биелэлт, үр дүнг аймгийн Засаг даргад тайлагнаж, дүгнүүлнэ.

2.11. Газар нь төрийн санд харилцах данстай байх бөгөөд өмч борлуулсны орлогыг Төрийн сангийн 100120000914 тоот дансанд төвлөрүүлнэ.

2.12. Орон нутгийн төрийн захиргааны байгууллага нь Орон нутгийн өмчийн газрын төсвийг дараа оны төсөвт тусгуулан батлуулж, батлагдсан төсвийг хуваарийн дагуу олгож, байгууллагын үйл ажиллагааг хангаж ажиллана.

Гурав. Албан хаагчийн үйл ажиллагаандаа мөрдөх зарчим

3.1 Газрын албан хаагч бүр Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчийн ёс зүйн дүрэмд зааснаас гадна дараах зарчмуудыг баримтална. Үүнд:

3.1.1. Аливаа шийдвэрийн төслийг хууль бусаар олж авахыг оролдох, түүнийг бусдад өгөх, мэдээлэл тараах, бусад албан хаагчийг үндэслэлгүй гүтгэх, нэр хүндэд нь халдах, доромжлохыг хориглоно.

3.1.2. Албан үүргээ гүйцэтгэхдээ аль нэг улс төрийн намаас ангид байх, төр, засаг болон удирдах дээд шатны бодлого, шийдвэрийг хэрэгжүүлэхэд зөвхөн төвийг сахих, иргэдэд үйлчилгээг чирэгдэлгүй хүргэж, үйлчлэх.

3.1.3. Албан үүрэгтэйгээ холбоогүй асуудлаар нам, шашны үйл ажиллагаанд газрын нэрийн өмнөөс оролцохгүй байх.

3.1.4. Байгууллага, иргэдээс ирүүлсэн болон шийдвэр гаргуулахаар бүрдүүлсэн баримт материалыг хянан үзэж зохих шаардлага хангаагүй буюу дутуу материалыг дахин бүрдүүлэх талаар зөвлөгөө өгөх, иж бүрэн болсон тохиолдолд хүлээн авч, шийдвэрлүүлэх.

Дөрөв. Газрын үндсэн эрх үүрэг

4.1. Орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлогын төслийг боловсруулж, шийдвэрийн хэрэгжилтийг зохион байгуулна.

4.2. Газар нь төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, бусад хууль тогтоомж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, аймгийн ИТХ-ын даргын захирамж, аймгийн Засаг даргын захирамжийн хэрэгжилтийг орон нутгийн хэмжээнд зохион байгуулж, биелэлтэд хяналт тавина.

4.3. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах ажлыг зохион байгуулах, хувьчлалын болон түрээсийн орлогыг орон нутагт төвлөрүүлнэ.

4.4. Орон нутгийн өмчийн эд хөрөнгийг зохих шийдвэрийн дагуу балансаас балансад шилжүүлэх, акталж, устгах, худалдан авах, худалдан борлуулах ажлыг зохион байгуулж, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хэлэлцүүлэн үр дүнг тайлагнана.

4.5. Орон нутгийн өмчийн бүртгэл судалгааг батлагдсан маягт, журмын дагуу бүтэн жилээр Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт хүргүүлнэ.

4.6. Орон нутгийн өмчийг хуульд нийцүүлэн зориулалтын дагуу үр ашигтай ашиглуулах, эзэмшилт ашиглалтгүй байгаа өмчийг хуулийн этгэдэд эзэмшүүлэх, улсын болон орон нутгийн төсөв, хандив, тусламж, зээл, бусад эх үүсвэрээр бий болсон өмч, хөрөнгийг зүй бусаар ашиглах, завших, үрэгдүүлэх явдлыг таслан зогсоох арга хэмжээ авах, уг ажилд эрх бүхий мэргэжлийн байгууллага, хэлтэс, албадыг татан оролцуулж, хамтран ажиллах

4.7. Орон нутгийн өмчийн холбоотой мөрдөх хууль, дүрэм, журмуудыг хуульд нийцүүлэн сурталчлах, биелэлтэд хяналт тавина.

4.8. Орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны чиглэлээр аймгийн Засаг даргыг бодлогын зөвлөгөө, дэмжлэгээр байнга хангаж ажиллана.

4.9. Орон нутгийн өмчийн талаар баримтлах бодлого, чиглэлийг аймгийн стратеги чиглэлд тусгаж, хэрэгжилтийг хангана.

4.10. Орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдэд өмчийн төлөөлөл хэрэгжүүлнэ.

4.11. Орон нутгийн өмчийн тооллогын ажлыг зохион байгуулж, дүнг тайлагнана.

4.12. Сум, орон нутгийн өмчит байгууллагуудыг өмчийн асуудлаар мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана.

4.13. Орон нутгийн өмчит байгууллагуудын өмчийн эрхтэй холбоотой гэрээ, хэлцлийг дүгнэж, эзэмших эрхээ зөрчсөн, хөрөнгийг хууль бусаар зарцуулсан, гэрээний биелэлтийг хангаагүй албан тушаалтанд арга хэмжээ тооцох талаар

дүгнэлт гарган холбогдох байгууллагад хүргүүлж, гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулан ажиллана.

Тав. Дүрэм зөрчигчдөд хүлээлгэх хариуцлага

5.1. Энэхүү дүрмийг зөрчигчдөд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу хариуцлага хүлээлгэнэ.

Зургаа. Бусад

6.1. Энэхүү дүрэм нь батлагдсан өдрөөсөө эхлэн хүчин төгөлдөр болно.

№	Төрөл	Хариуцагч	Тусламж, зөвөгдөл	Тоо
1	Срэн бүтцийн зарчгийн газрын дарга	Удирдах	Ахлах тусламж, ТЗ-4	1
2	Боловсролын үндэсний газрын дарга	Гүйцэтгэх	Дэс тусламж, ТЗ-8	1
3	Сургалтын бүртгэл, мангилт	Гүйцэтгэх	Дэс тусламж, ТЗ-8	1
4	Боловсролын үндэсний газрын дарга	Гүйцэтгэх	Дэс тусламж, ТЗ-9	1
5	Боловсролын үндэсний газрын дарга	Гүйцэтгэх	Дэс тусламж, ТЗ-9	1
6	Харьяаны бүртгэл, мангилт	Гүйцэтгэх	Дэс тусламж, ТЗ-9	1
7	Боловсролын үндэсний газрын дарга	Гүйцэтгэх	Дэс тусламж, ТЗ-9	1
8	Хууль зох аян, дотоод ажил, хөдөлмөр, нөөц хариуцсан мангилтан	Гүйцэтгэх	Дэс тусламж, ТЗ-9	1
9	Нэгтгэн бодал	Гүйцэтгэх	ТЗ-8	1
10	Ажил, бичиг хариуцагч	Гүйцэтгэх	ТЗ-6	1
11	Нараа, жолооч	Гүйцэтгэх	ТЗ-4	1
12	Удирдах	Гүйцэтгэх	ТЗ-3	1
Срэн төрөл дэмж зөвөгдөл				12


2023 оны 11 дүгээр сарын 30 -ны өдрийн
1/663 дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ
АГЕНТЛАГ ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН БҮТЭЦ, ОРОН ТОО,
АЛБАН ТУШААЛЫН ЖАГСААЛТ**

№	Албан тушаалын нэр	Албан тушаалын төрөл	Албан тушаалын ангилал, зэрэглэл	Орон тоо
1	Орон нутгийн өмчийн газрын дарга	Удирдах	Ахлах түшмэл, ТЗ-4	1
2	Өмчийн удирдлага, хяналт хариуцсан ахлах мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-8	1
3	Өмчийн бүртгэл, ашиглалт хариуцсан ахлах мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-8	1
4	Өмчийн удирдлага, төлөөлөл хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
5	Өмчийн хяналт шалгалт хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
6	Хөрөнгийн бүртгэл, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
7	Өмчийн ашиглалт, зохицуулалт хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
8	Хууль эрх зүй, дотоод ажил, хүний нөөц хариуцсан мэргэжилтэн	Гүйцэтгэх	Дэс түшмэл, ТЗ-9	1
9	Нягтлан бодогч	Гүйцэтгэх	ТҮ-8	1
10	Архив, бичиг хэргийн эрхлэгч	Гүйцэтгэх	ТҮ-5	1
11	Нярав, жолооч	Гүйцэтгэх	ТҮ-4	1
12	Үйлчлэгч	Гүйцэтгэх	ТҮ-3	1
Орон тооны дээд хязгаар:			12	

-----oOo-----

Аймгийн Засаг даргын
А/663... 11 дүгээр сарын 30-ны өдрийн
дугаар захирамжийн хоёрдугаар хавсралт



АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ГАЗРЫН БҮТЭЦ,
ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮДҮҮВЧ ЗУРАГ

